

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/87/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Арвайхээр
2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Аудитор: Р.Энхзул

Утас: 70323833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.13 № 19
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн

015000037

болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	20,809,568.01
35	БАРАА МАТЕРИАЛ	-	20,809,568.01
351	Түүхий эд материал	-	2,431,600.00
35110	Тусгай зориулалттай материал	-	2,315,100.00
35130	Эм боох материал	-	116,500.00
354	Хангамжийн материал	-	18,377,968.01
35410	Бичиг хэргийн материал	-	665,280.00
35420	Аж ахуйн материал	-	3,074,050.00
35440	Түлш, шатах тослох материал	-	382,600.01
35450	Барилгын засварын материал	-	5,816,950.00
35460	Хүнсний материал	-	3,230,388.00
35470	Бусад хангамжийн материал	-	5,208,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	481,473,621.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	481,473,621.90
392	Биет хөрөнгө	-	480,758,621.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	449,967,508.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,499,458.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	26,740,480.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,953,244.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	8,280,449.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(495,287.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	7,838,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,120,325.02)
393	Биет бус хөрөнгө	-	715,000.03
39301	Програм хангамж	-	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(164,999.97)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	502,283,189.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	165,059.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	165,059.00
413	Өглөг	-	165,059.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	165,059.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	502,118,130.91
51	Засгийн газрын хувь оролцоо	-	502,118,130.91
512	Хуримтлагдсан үр дүн	-	502,118,130.91
51220	Тайлант үеийн үр дүн	-	502,118,130.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	502,283,189.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	621,480,639.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	473,917,679.42
120	Нийтлэг татварын бус орлого	-	473,917,679.42
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	-	467,388,979.42
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	-	6,528,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	147,562,960.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	128,939,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	128,939,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	498,260.00

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	498,260.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	18,125,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	18,125,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	119,362,508.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	119,362,508.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	107,932,595.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	78,179,116.02
210101	Үндсэн цалин	-	64,996,874.02
210102	Нэмэгдэл	-	5,271,986.00
210104	Урамшуулал	-	7,910,256.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	11,082,058.31
210201	Тэтгэврийн даатгал	-	7,599,916.87
210202	Тэтгэмжийн даатгал	-	849,843.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	634,675.80
210204	Ажилгүйдлийн даатгал	-	172,793.45
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,824,828.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	3,609,372.00
210301	Гэрэл, цахилгаан	-	1,099,372.00
210302	Түлш, халаалт	-	2,360,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,119,579.99
210401	Бичиг хэрэг	-	754,720.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,253,999.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	834,600.00
210404	Ном, хэвлэл	-	106,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	57,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,112,460.00
2105	Нормативт зардал	-	3,789,212.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	64,100.00
210502	Хоол, хүнс	-	3,465,012.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	260,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,153,257.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	419,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	4,733,857.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	11,429,912.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	136,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	136,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,414,184.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,414,184.67
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,879,028.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,879,028.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	502,118,130.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	502,118,130.91

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	502,118,130.91	0.00	502,118,130.91
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	502,118,130.91	0.00	502,118,130.91

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	147,562,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	147,562,960.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	128,939,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	128,939,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	498,260.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	498,260.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	18,125,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	18,125,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	128,744,460.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	128,744,460.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	117,314,547.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	78,014,057.02
210101	Үндсэн цалин	-	64,897,071.02
210102	Нэмэгдэл	-	5,271,986.00
210104	Урамшуулал	-	7,845,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	11,082,058.31
210201	Тэтгэврийн даатгал	-	7,599,916.87
210202	Тэтгэмжийн даатгал	-	849,843.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	634,675.80
210204	Ажилгүйдлийн даатгал	-	172,793.45
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,824,828.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	4,245,972.00
210301	Гэрэл, цахилгаан	-	1,099,372.00
210302	Түлш, халаалт	-	2,767,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	379,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,047,360.00
210401	Бичиг хэрэг	-	351,700.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	834,600.00
210404	Ном, хэвлэл	-	106,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	57,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,697,260.00
2105	Нормативт зардал	-	7,196,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	243,400.00
210502	Хоол, хүнс	-	6,692,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	260,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,030,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,030,000.00
210604	Урсгал засвар	-	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	752,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	752,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	945,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	945,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	11,429,912.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	136,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	136,700.00

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,414,184.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,414,184.67
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,879,028.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,879,028.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	18,818,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	18,818,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	18,818,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	18,818,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	18,818,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(18,818,500.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	147,064,100.00	135,771,487.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,064,100.00	135,771,487.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,927,400.00	135,634,787.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79,966,900.00	78,014,057.02
210101	Үндсэн цалин	60,769,900.00	64,897,071.02
210102	Нэмэгдэл	7,236,800.00	5,271,986.00
210104	Урамшуулал	11,960,200.00	7,845,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,542,800.00	11,082,058.31
210201	Тэтгэврийн даатгал	7,369,900.00	7,599,916.87
210202	Тэтгэмжийн даатгал	1,793,200.00	849,843.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,434,600.00	634,675.80
210204	Ажилгүйдлийн даатгал	358,600.00	172,793.45
210205	Эрүүл мэндийн даатгал	3,586,500.00	1,824,828.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,125,000.00	4,245,972.00
210301	Гэрэл, цахилгаан	1,795,000.00	1,099,372.00
210302	Түлш, халаалт	6,330,000.00	2,767,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	379,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,749,100.00	6,749,100.00
210401	Бичиг хэрэг	351,700.00	351,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	834,600.00	834,600.00
210404	Ном, хэвлэл	106,200.00	106,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	57,600.00	57,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,399,000.00	4,399,000.00
2105	Нормативт зардал	7,196,400.00	7,196,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	243,400.00	243,400.00
210502	Хоол, хүнс	6,692,900.00	6,692,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	260,100.00	260,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,490,000.00	15,490,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,490,000.00	7,490,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,111,400.00	2,111,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,111,400.00	2,111,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,745,800.00	10,745,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,800,000.00	9,800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	945,800.00	945,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,700.00	136,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,700.00	136,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	136,700.00	136,700.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	498,260.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	498,260.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	498,260.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	498,260.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	498,260.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хүүхдийн хоолны зардлыг нормативаас 92.0 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн зорилго нь бага насны хүүхэд бүрийн авьяас сонирхолд тулгуурлан тэдний бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйг тоглонгоо, бүтээлч үйлээр нь хөгжүүлэх, оюун ухааны тоглоом шатар, монгол ёс заншил, мэндлэх ёсоор анхдагч зөв хүмүүжил, чадамжийг эзэмшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 119362.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1193.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 954.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө 493706.9 мянган төгрөгөөр өссөн нь 18818.5 мянган төгрөгөөр худалдан авсан, 24920.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан, 449967.5 мянган төгрөгөөр шилжиж ирсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Бараа материал 20809.6 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэг нь шинээр байгуулагдсан тул төсвийн төслийг төлөвлөөгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд онд 147064.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 147064.1 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 11292.6 мянган төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Тайлант оны нийт төсвийн гүйцэтгэл 135771.5 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлтээр 498.3 мянган төгрөгийг санхүүжүүлэн, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэхэд цэвэр, бохир усны зардлаас шатахууны зардалд зориулалт бус зарцуулсан, цалин хөлсийг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан, хүүхдийн хоолны зардлыг нормативаас хэтрүүлэн зарцуулсан, шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5, 6.4.8 дахь заалтуудын мэдээллийг дутуу мэдээлсэн зэрэг зөрчил илэрлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 24 мэдээлэл мэдээлээгүй, 50 мэдээллийг хугацаанд нь, 76 мэдээлэл хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэн албан шаардлага өгсөн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2021 онд шинээр байгуулагдсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 29217.4 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

4.1 Залруулсан алдаа

Залруулга байхгүй

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Цэвэр, бохир усны зардлаас шатахууны зардалд 229.6 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан, 415.8 мянган төгрөгийн цалин хөлсийг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан, Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5, 6.4.8 дахь заалтуудын 28480.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зэрэг зөрчилд албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Хүүхдийн хоолны зардлыг нормативаас 92.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэг	4	29217.4					3	29125.4	1	92.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Р.ЭНХЗУЛ

